



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/НЧВ

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 75 дугаар дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Арвайхээр сумын хүнс бараан захад бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд ажлын байр барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 88308500 (наян найман сая гурван зуун найман мянга таван зуу) төгрөгөөр “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100780